



## ЯПОН УЛСЫН ОЮУНЫ ӨМЧИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Оюуны өмчийн эрх зүйн маргаан<sup>1</sup>)

### ИНТЕРНЭТ ТОГЛООМУУДЫН ТОДОРХОЙ ХЭСЭГ АДИЛ ТӨСТЭЙ БАЙХ НЬ ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ БОЛОХ УУ? : “TSURI-GE TOWN” ХЭРЭГ

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** Heisei 24 (Ne) №10027<sup>2</sup>

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2012 оны 8 дугаар сарын 8-ны өдөр.

**Шийдвэрийн төлөв:** Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

#### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч болон хариуцагчид нь загас барих сэдэвтэй гар утсанд зориулсан интернэт тоглоом тус тусдаа (цаашид тус бүр “Х бүтээл”, “Ү бүтээл” гэх) бүтээж, олон нийтэд дамжуулж байжээ. Нэхэмжлэгч нь хариуцагч нарын дээрх үйлдэл нь Х бүтээлтэй холбоотой зохиогчийн эрх<sup>3</sup> болон зохиогчийн эдийн бус амины эрхийг<sup>4</sup> зөрчсөн гэж үзэн, (1) Зохиогчийн эрхийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн дагуу Ү бүтээлийг олон нийтэд интернэтээр дамжуулахыг зогсоолгох, дүрс бичлэгийг вэбсайт болон мэдээлэл хадгалах хэрэгслээс устгахыг даалгах, (2) Иргэний хуулийн 709 дүгээр зүйлийн дагуу хохирлоо нөхөн төлүүлэх зэрэг шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан.

Нэхэмжлэгчээс зохиогчийн эрх нь зөрчигдсөн хэмээн маргасан зүйл нь Ү бүтээл дэх “загас агнах дэлгэц” байв. Нэхэмжлэгч нь “загас агнах дэлгэц” гэдгийг ижил төвтэй тойргууд дүрслэгдсэнээс хойших дэлгэцийг ойлгож байгаа бөгөөд төвийн тойргийн хэсэгт загасны дүрс байрлаж байх үед шийдвэрлэх товчийг дарснаар гарч ирдэг анимейшн дүрслэлийг хасаж, үлдсэн хэсгийг тодорхойлон заасан байна. Түүнчлэн нэхэмжлэгч нь “загас агнах дэлгэц”-ийн хүрээнд зөвхөн усан доорх орчныг дүрсэлсэн зураг ашигласан, дүрслэлийн өнцөг нь хажуугаас харсан байдлаар хэвтээ чиглэлд тогтмол хадгалагдсан зэрэг хэд хэдэн элемент нь Х

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

<https://www.courts.go.jp/hanrei/82492/detail8/index.html>

Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

<sup>2</sup> 知財高等平成 24 年 8 月 8 日 判決判例タイムズ 1403 号 271 頁。

Intellectual Property High Court Judgement, Heisei 24 · 8 · 8, Hanrei taimuzu, no.1403, 271.


<sup>3</sup> Японы Зохиогчийн эрхийн тухай хуулийн 27 дугаар зүйл дэх “бүтээлийг үүсмэл бүтээл болгон өөрчлөх эрх” болон мөн хуулийн 28 дугаар зүйлд үндэслэсэн “бүтээлийг нийтэд дамжуулах эрх”

Японы Зохиогчийн эрхийн тухай хуулийг англи хэлээр дараах сайтаар харна уу <https://www.wipo.int/wipolex/en/legislation/details/21342> (Last visited : 2026.06.08).

<sup>4</sup> Японы Зохиогчийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйл дэх “бүтээлийн бүрэн бүтэн байдлыг хадгалах эрх”

бүтээлийн илэрхийллийн мөн чанарыг бүрдүүлэгч онцлог шинж бөгөөд эдгээр шинжүүд нь Ү бүтээлд мөн ажиглагдаж байна гэж маргажээ.

“Tsurige Town” хэрэг дэх Х бүтээл(зүүн) болон Ү бүтээл (баруун)<sup>5</sup>



### ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР:

**Анхан шатны шүүхийн шийдвэр:** Анхан шатны шүүхээс нэхэмжлэгчийн зохиогчийн эрх болон зохиогчийн эд хөрөнгийн бус амины эрх зөрчигдсэн гэж үзэж, нэхэмжлэлийн зарим хэсгийг ханган шийдвэрлэсэн.<sup>6</sup> Өөрөөр хэлбэл, шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн (1) дэх шаардлагыг бүхэлд нь, мөн (2) дахь шаардлагын хүрээнд нийт 234,600,000 иен болон түүнд ногдох хугацаа хэтрүүлсний хохирлыг нөхөн төлүүлэх хэсгийг хангаж шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч уг шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах шүүхэд гомдол гаргасан бөгөөд хохирол нөхөн төлүүлэх шаардлагаа нэмэгдүүлж, 2011 оны 7 дугаар сарын 8-наас 2012 оны 3 дугаар сарын 8-ны өдрийг хүртэлх хугацаанд учирсан хохиролд 128,650,000 иен болон түүнд ногдох хугацаа хэтрүүлсний хохирлыг нэмж нэхэмжилсэн. Мөн хариуцагчаас шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан.

**Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:** Оюуны өмчийн давж заалдах шатны шүүхээс доор дурдсан үндэслэлүүдийн дагуу нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

1. Шүүхээс Х болон Ү бүтээлүүдийн нийтлэг хэсгүүд нь “илэрхийлэл биш хэсэг, эсхүл илэрхийллийн бүтээлч шинжийг агуулаагүй хэсэг бөгөөд, тодорхой илэрхийллийн хувьд ч хоорондоо ялгаатай” гэж дүгнэжээ. Түүнчлэн шийдвэрлэх товчийг дарахад гарч ирэх анимейшн дүрслэл, ижил төвтэй тойргууд харагдахаас өмнөх дэлгэц зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзээд, хоёр бүтээл нь олон төрлийн тодорхой илэрхийллийн хувьд харилцан ялгаатай гэж үзжээ.
2. Үүний үндсэн дээр “Дээрх нийтлэг болон ялгаатай хэсгүүдийн агуулга, бүтээлч шинжийг агуулсан эсэх болон түүний түвшинг харгалзан үзвэл, Ү бүтээлийн загас агнах дэлгэцийг харж мэдэрч буй этгээдэд тухайн дэлгэц

<sup>5</sup> 東京地判平成 24 年 2 月 23 日 (LEX/DB 平 21 (ワ) 34012 号) 7 頁より引用。

Tokyo District Court Judgment, February 23, 2012 (LEX/DB No. Heisei 21 (Wa) 34012), 7. <https://www.courts.go.jp/hanrei/82118/detail7/index.html> 2026.06.08 saishū etsuran).

<sup>6</sup> Мөн тэнд.



- бүхэлдээ төрүүлэх сэтгэгдэл нь Х бүтээлийнхээс өөр байх бөгөөд Х бүтээлийн илэрхийллийн мөн чанарыг бүрдүүлэгч онцлог шинжүүдийг шууд мэдрэн таних боломжтой гэж үзэхгүй” гэж дүгнэжээ.
3. Дээрх дүгнэлтээ дэлгэрүүлэн “Нэхэмжлэгч тус бүрийн элементүүдийг дангаар нь авч үзвэл илэрхийллийн бүтээлч шинжийг агуулаагүй байсан ч, олон элемент нийлээд бүхэлдээ илэрхийллийн бүтээлч шинжийг бүрдүүлж болох тул ... тухайн бүтээлийг тус тусын бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан хувааж, хэсэг бүрээр нь бүтээлч шинж байгаа эсэх, санаа эсвэл илэрхийлэл эсэхийг дүгнэх нь зохистой биш гэж маргасан. Гэвч зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээлийн бүтээлч илэрхийлэл нь төрөл бүрийн бүтээлч элементүүдийн нэгдлээс бүрэлдэн тогтдог учраас Х бүтээл болон Ү бүтээлийн нийтлэг хэсэг нь илэрхийлэл гэж үзэгдэх боломжтой эсэх, мөн илэрхийллийн бүтээлч шинжтэй эсэхийг тогтоохдоо түүний бүрэлдэхүүн элементүүдийг шинжилж, элемент тус бүрийг илэрхийлэл гэж үзэж болох эсэх, түүнчлэн илэрхийллийн бүтээлч шинж агуулж байгаа эсэхийг судлан үзэх нь чухал төдийгүй зайлшгүй шаардлагатай юм. Үүний дараа Х бүтээлийг бүхэлд нь, эсхүл эрхийн зөрчил байгаа гэж маргаж буй тухайн хэсгийг бүхэлд нь авч үзэн, түүнийг илэрхийлэл гэж үзэж болох эсэх, мөн илэрхийллийн бүтээлч шинжтэй эсэхийг дүгнэх нь үндэслэлтэй дүгнэх арга гэж хэлж болно.” гэж тайлбарлажээ.
  4. Мөн “Бүтээлийг үүсмэл бүтээл болгон өөрчлөх эрхийн зөрчил байгаа эсэх нь маргааны зүйл болсон хэрэгт зохиогчийн эрх эзэмшигч болох нэхэмжлэгч нь өөрийн бүтээлийн тодорхой нэг хэсгийг зөрчигдсөн гэж үзэж байгаа тохиолдолд юуны өмнө зөрчигдсэн гэж үзэж буй өөрийн бүтээл дэх хэсгээ тодорхойлон тогтоож, дараа нь эрхийн зөрчил байгаа гэж үзэж буй зүйлтэй харьцуулан өөрийн шаардлагаа нотлох үүрэгтэй. Тухайн хэсэг нь өөрөө нэгдмэл шинжтэй зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээл гэж үзэж болохуйц байвал, талууд уг хүрээний дотор эрх зөрчигдсөн эсэх, эсхүл зөрчигдөөгүй эсэх талаар өөрсдийн байр сууриа нотлох үүрэгтэй. ... Ийнхүү зохиогчийн эрх эзэмшигч нь нэгдмэл шинжтэй бүтээлийн зарим хэсгийг хасаж, зөвхөн тодорхой хэсгийг харьцуулалтын объект болгон нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлсон тохиолдолд хариуцагч тал нь уг нэгдмэл бүтээлээс хасагдсан хэсгүүдийг мөн оролцуулан харьцуулсан үед бүтээлийн илэрхийллийн мөн чанарыг бүрдүүлэгч онцлог шинжийг шууд мэдрэн таних боломжгүй болохыг нотлох нь (хэрэв энэ нь “загас агнах дэлгэц”-ийн хүрээнээс хэтрээгүй бол) маргааны зүйлийн үүднээс зөвшөөрөгдөхгүй гэж тайлбарлах үндэслэл байхгүй.” гэж үзжээ.
  5. Давж заалдах шатны шүүхээс дээрх дүгнэлтүүдийг үндэслэн хариуцагчийн үйлдэл нь зохиогчийн эрх болон зохиогчийн эдийн бус амины эрхийн зөрчил биш гэж шийдвэрлэжээ.